



ДУНДГОВЬ АЙМАГ  
ДЭЛГЭРЦӨГТ СҮМҮН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2021 оны 05 сарын 08 наадр

Дугаар 8/56

Амардалай

Зохион байгуулалтын арга хэмжээ  
авах тухай

Монгол улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, тууний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6-ын "а", Гамшигаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1 дэх заалт, Засгийн газрын 2021 оны 115 дугаар тогтоол, Улсын Онцгой комиссын 2021 оны 17 дугаар хурлын шийдвэр, аймгийн Онцгой комиссын 14 дүгээр хурлын шийдвэр, аймгийн Засаг даргын 2021 оны А/180 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Коронавирус (Ковид-19)-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, эрсдлийг бууруулах зорилгоор 2021 оны 05 дугаар сарын 08 нийн өдрийн 06.00 цагаас 2021 оны 06 дугаар сарын 02 ны өдрийг хүртэлх хугацаанд гамшигаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсүгэй.

2. Дээрх хугацаанд сумын нутаг дэвсгэрт олон нийтийг хамарсан уралдаан тэмцэн, сум хийдийн болон бусад хурал цуглаан, үзэсгэлэн худалдаа, аялал зугаалга, хурим найр, спорт заал, жуулчны баазыг 2021 оны 05 дугаар сарын 08 ны өдрөөс 2021 оны 06 дугаар сарын 02 ны өдөр хүртэл хугацаанд хориглосугай.

3. Дээрх хугацаанд сумын хэмжээнд ажиллаж буй шалган нэвтрүүлэх хяналтын цэгүүдээр нэвтрэх байгаа коронавируст халдвараас сэргийлэх дархлаажуулалтын 2 тунд бурэн хамрагдсанас хойш 14 хоног болсон, суулийн 4 сарын хугацаанд халдвараар өвчилж адгэрсан иргэдээс бусад иргэдийг PCR шинжилгээний хариуг шалгаж, түргэвчилсэн шинжилгээнд хамруулан нэвтрүүлж, тусгаарлан ажиглах байранд авч 7 хоног хяналт тавьж, шинжилгээний дүнг үндэслэн гэрийн ажиглалтад шилжүүлэх арга хэмжээ авч ажиллахыг ЭМТ-ийн дарга /Т.Мөнхтуяа/-д үүрэг болгосугай.

4. Хот, сум хоорондын зорчигч тээврийн хэрэгслийн хеделгэенийг аймгийн Онцгой комиссист уламжлан хязгаарлаж, дамжин енгөрөх буй тээврийн хэрэгслийг зогсоохгүй өнгөрүүлэхээр зохицуулж аж ахуйн нэгж, хувийн хэвшлийн ажиллах цагийн хуваарийг 09.00 цагаас 19.00 цагийн хооронд байхваар тогтоож, хяналт тавьж ажиллахыг Цагдаагийн хэсгийн төлөөвлөгөө /Л.Отгонбаатар/-т үүрэг болгосугай.

488010 162

5. Төв зам дээр гарах пост болон хадалгоеент эргүүлийн хуваарийг хавсралтаар баталж, жижүүрүүдийг үүрэгжүүлж, хяналт тавьж ажиллахыг Онцгой комиссын пишуудад даалгасугай.

6. Архи, согтууруулах ундаа худалдан борлуулах туугзэр уйлчлэх аж ахуйн нэгжүүдэд 18 градусаас доош спиртийн агууламжтай согтууруулах ундаа худалдан борлуулах, түүгзэр уйлчлэхийг 2021 оны 05 дугаар сарын 08 ны өдрээс эхлэн зөвшөөрсүгэй.

7. Дээрх хугацаанд улсын чанартай автозам дагуух цайны газруудын уйл ажиллагааг хориглосугай.

8. Сумын нутаг дэвсгэрт барилга, бүтээн байгуулалтын уйл ажиллагаа явуулах аж ахуйн нэгж, байгууллагуудын ажилчдыг нэвтрүүлэх дүрэм журмыг мөрдүүлэн, хяналт тавьж ажиллахыг ЭМТ-ийн дарга /Т.Мөнхтуяа/, Хэсгийн төвөөлөгч /Л.Отгонбаатар/ нарт үүрэг болгосугай.

9. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг сумын Засаг даргын орлогч Л.Золжаргал/-д даалгасугай.



